

**ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМИЙГ САЙЖРУУЛЖ, УРГАЦЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЗОРИЛГООР БОРДОО ХЭРЭГЛЭСЭН ТАРИАЛАНЧ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
БОРДООНЫ ҮНИЙН ДҮНГИЙН 30 ХҮРТЭЛ ХУВЬД ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ
БАРИМТ БИЧИГ**

Үндэслэл	<p>- “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолын Газар тариалангийн чиглэлийн е хэсэгт “Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх”,</p> <p>- Тогтоолын хавсралт төлөвлөгөөний 3.6.2-дахь хэсэгт “Бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох” гэж тус тус заасан.</p> <p>- ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын 2022 оны А/218, А/146 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ын 3.1.1-д “эзэмшиж ашиглаж буй тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах чиглэлээр “Тариалангийн тухай “ хуулийн 19.5.2 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх гэж заасан.</p>
1. Зорилго	<p>"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.6.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах, хөрсний үржил шимийг сайжруулахад оршино.</p> <p>Дотоодын бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дотоодод үйлдвэрлэл хөгжөөгүй эрдэс, органик бордооны импортын хангамжийг сайжруулахад оршино.</p>
2. Оролцогч талууд	<p>- Дотоодын бордоо үйлдвэрлэгч хуулийн этгээд</p> <p>- Эрдэс бордоо импортлогч хуулийн этгээд/ХХБАБЭИХДТҮАХУ-ААН ҮА-ны тусгай зөвшөөрөлтэй байх.</p> <p>- Органик, биологийн гаралтай бордоо импортлогч аж ахуйн нэгжүүд</p> <ul style="list-style-type: none"> ○ Тариаланч иргэн, хуулийн этгээд ○ ХХААХҮЯ-ны БТГ, СХОГ, ГТБХЗГ <p>Арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч аж ахуйн нэгж нь Монгол Улсын хуулийн этгээд байна.</p>
3. Төслийн цар хүрээ	<p>1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь бордоо нийлүүлэх үйл ажиллагааг “Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн үйл ажиллагаа”-ны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд, “Монгол улсад 2024 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох биобэлдмэлүүдийн жагсаалт”-аас дор дурдсан нэр төрлийн органик, биологийн гаралтай бордоо импортлосон хуулийн этгээд, бордоо үйлдвэрлэдэг патент, стандарттай дотоодын аж ахуйн нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлнэ.</p>
4. Хөнгөлөлтөд хамрагдах Бордооны төрөл	<p>1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024.02.26-ны өдрийн А/96, А/104, А/81 дугаар тушаалаар батлагдсан “Жагсаалт батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтын жагсаалтанд орсон доорхи нэр төрлийн химийн гаралтай бордоо,</p>

	<p>2. Хөдөө аж ахуйн салбарт ургамал хамгаалал, хөрсний үржил шимийг сайжруулах зориулалтаар ашиглах биологийн гаралтай бодисын талаар мэргэжлийн санал дүгнэлт, гаргах орон тооны бус Салбар зөвлөлийн хурлаар баталсан “Монгол улсад 2024 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох биобэлдмэлүүдийн жагсаалт”-д орсон доорхи нэр төрлийн органик, биологийн гаралтай бордоог хөнгөлөлтөд хамруулна.</p> <p>А. Дотоодын үйлдвэрийн бордоо:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дархан-Ризо био шингэн бордоо 2. Дархан- гумат органик бордоо 3. Гумины бордоо 4. Био ялзмагийн бордоо 5. Компост-Эм 6. Ризобактер болон бактерийн бордоо 7. Азофос био бордоо 8. ЕМ-1 бордоо 9. Түмэн шувуут компост бордоо 10. Мон эрдэст органик бордоо 11. “Мон шимт-эрдэс” органик-эрдэс үрлэн нийлмэл бордоо 12. Ноосон бордоо 13. Шимт бор органик бордоо 14. Мимо эрдэс бордоо 15. Бона бордоо 16. Биогум органик шингэн бордоо 17. Биостим органик шингэн бордоо <p>Б. Импортын бордоо</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүвтрийн шүү /35-0-0/ 2. Фосфорын бордоо /0-46-0/ 3. Калийн бордоо /60-62/ 4. Мочевин /46-0-0/ Азот 5. Азот фосфорын хүхэрийн нийлмэл бордоо NPS 6. Нийлмэл бордоо /NPK/ 7. Гумины хүчилд суурилсан бордоонууд 8. Органик бордоо <p>Жич: Дараах химийн бордоо, өсөлт зохицуулагчийг хөнгөлөлтөд хамруулахгүй. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол улсад 2024 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох биобэлдмэлүүдийн жагсаалтын “Өсөлт зохицуулагч”-ийн ангилалд батлагдсан бодис, бэлдмэл; 2. Уул уурхайн тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй компаниар импортлогдсон болон уул уурхайн тэсэлгээний зориулалтаар импортлож хөдөө аж ахуйн зориулалтаар хэрэглэсэн химийн бордоо; 3. Хөдөө аж ахуйн корпорацид 2023 онд нийлүүлэгдсэн азотын бордоонд хөнгөлөлт олгохгүй.
5.Хөнгөлөлтийн нөхцөл:	<ol style="list-style-type: none"> 1. Хөрсний үржил шимийг сайжруулж, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоо төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд хэрэглэсэн тариаланч хүн, хуулийн этгээдийн бордооны үнийн дүнгийн 30 хувьд, үр тариа болон бусад таримлын тариалангийн үйлдвэрлэлд хэрэглэсэн тариаланч хүн, хуулийн этгээдийн бордооны үнийн дүнгийн 30 хүртэл хувьд хөнгөлөлт олгоно.

	<p>2. Тариалан эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь энэ баримт бичгийн 7 дахь хэсэгт заасан нотлох баримтыг хавсаргасан хүсэлтээ цахимаар ирүүлсний дараа материалыг хянаж хөнгөлөлт үзүүлэхийг шийдвэрлэж төрийн сангаар дамжуулан бордоо худалдан авсан иргэн, хуулийн этгээдийн дансаар олгоно.</p> <p>3. Бордооны хөнгөлөлтийг хүн, хуулийн этгээдэд олгох дээд хязгаар 100,000,000(Нэг зуун сая) төгрөг байна.</p> <p>4. Импортлогч, үйлдвэрлэгчийн мэдүүлсэн жишиг үнээр бордооны үнийг тооцож бодолт хийнэ.</p> <p>5. Ирүүлсэн материал нь шаардлага хангаагүй тариаланчдад хөнгөлөлт үзүүлэхгүй ба үүнээс үүдэлтэй гарах зардлыг захиалагч хариуцахгүй.</p>
<p>6. Бордооны хөнгөлөлтийн хугацаа</p>	<p>1. Энэхүү баримт бичгээр бордооны хөнгөлөлтөд хамрагдах тариаланч иргэн, хуулийн этгээд худалдан авсан бордооны НӨАТ-ын баримтын үүсгэх хугацааг 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл тооцно.</p> <p>2. Тариаланчдын хэрэглэсэн бордоонд хөнгөлөлт үзүүлэх материалыг Газар тариалангийн бүртгэлийн нэгдсэн plant.mofa.gov.mn цахим системийн “Дэмжлэг” хэсгийн “Бордоо” цэсээр 10 дугаар сарын 10-ний өдрийг хүртэл хүлээн авна.</p> <p>3. Материал хянан шалгах хугацаа 2024.11.15 хүртэл.</p> <p>4. Хугацаа хожимдуулсан материал хүлээн авахгүй ба хөнгөлөлт үзүүлэхгүй.</p>
<p>7. Бордооны хөнгөлөлтөд хамрагдах тариаланчдад тавигдах шаардлага</p>	<p>1. Тариалан эрхэлдэг www.plant.mofa.gov.mn цахимд бүртгэлтэй байх, хэрэглэсэн бордоогоо тариаланчийн тэмдэглэлд бүртгэсэн байх. Цахим бүртгэл болон тариаланчийн тэмдэглэлд бордоо хэрэглэсэн талбай, хугацаа, тун, тусгаагүй нь хөнгөлөлтөөс хасах үндэслэл болно.</p> <p>2. Тариаланч цахим системд талбайн хэмжээ болон таримлын нэр төрлөөр оруулсан байх.</p> <p>3. Бордоо худалдах, худалдан авах гэрээ байх ба төлбөрийн Е-баримтаар нотолно. Гэрээнд заавал нийлүүлэгчээс авсан бордооны худалдааны нэр, үйлчлэх бодисын нэр, хувь, хэмжээ, биткус код, олон улсын бүртгэлийн дугаар CAS, стандарт, патент, тоо хэмжээний талаарх мэдээллийг хавсаргаж нотолно/</p> <p>4. Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.8 дахь заалтын дагуу өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа тариалангийн газарт агрохими, агрофизикийн шинжилгээг 2020-2024 оны аль нэг жилд хийлгэсэн байх ба шинжилгээ хийсэн лабораторийн дүнг хавсаргана.</p> <p>5. Тариаланч нь өөрөө бордоо импортлон борлуулагч байж болно. Нотолгоо ирүүлнэ. /импортлогч нарт тавигдах шаардлага хангасан байна/.</p> <p>6. Бордооны дотоодын үйлдвэрүүд үйлдвэрлэл явуулсан санхүүгийн тайлангаар нотолно. Харилцан хамаарал бүхий этгээд хоорондоо бордоо худалдсан бол Е-баримт, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн баримтаар нотолно.</p> <p>7. Бордоо хэрэглэсэн талбайн зураг, явцын үр дүнгийн талаар фото зураг PDF файл хавсаргана.</p>
<p>8. Бордоо үйлдвэрлэгч, Бордоо импортлох</p>	<p>Бордоо нийлүүлэх хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.</p> <p>1.Газар тариалангийн зориулалтаар Бордоо үйлдвэрлэх, импортлох(тусгай) зөвшөөрөлтэй байх</p>

зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд тавигдах шаардлага	<p>2.Импортлосон бордооны нэр төрөл тоо хэмжээг тогтоосон гаалийн мэдэгдэл</p> <p>3.Борлуулсан бордооны нэр төрөл тоо хэмжээг борлуулалтын баталгаажсан татварын цахим төлбөрийн баримтын (E-barimt.mn) системд 43402 кодоор баталгаажуулсан байна.</p> <p>4.Худалдах бордоо нь лабораторийн шинжилгээний дүнтэй байна.</p> <p>5.Бордоо худалдах, худалдан авах гэрээ байх ба төлбөрийн баримтаар нотолно./Худалдан авсан, худалдсан төлбөрийн баримт/ Гэрээнд заавал бордооны худалдааны нэр, үйлчлэх бодисын нэр, хувь, хэмжээ, олон улсын бүртгэлийн дугаар CAS, стандарт, патент, бордооны тоо хэмжээг заасан баримтыг хавсаргаж нотолно/</p> <p>6.Импортлосон, үйлдвэрлэсэн болон борлуулсан бордооны нэр төрөл, тоо хэмжээ, борлуулалтын тайланг 2024 оны 10 дугаар сарын 1-ны дотор багтаан Plant.mofa.gov.mn цахим системд тайлагнана.</p> <p>7.Бордоо худалдсан хуулийн этгээд импортлосон болон үйлдвэрлэсэн бордооны зарцуулалтыг www.plant.mofa.gov.mn сайтад шивэлт хийсэн байна.</p>
9.Хөнгөлөлтийн санхүүжилт	<p>Арга хэмжээний нийт санхүүжилт 4,414,500,000.0 (Дөрвөн тэрбум дөрвөн зуун арван дөрвөн сая таван зуун мянга) төгрөг Улсын төсвийн ХХААХҮ-н сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны А/728 тушаалын 10 дугаар хавсралтын 32 дахь арга хэмжээний зардлаас санхүүжигдэнэ.</p>
10. Хяналт	<p>1. Бордооны хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, тун норм, хэрэглээнд салбарын хяналтын газрын аймаг орон нутаг дахь Хүнс хөдөө аж ахуйн газрын агрономч, ургамал хамгааллын хяналтын улсын байцаагчид хяналт тавина.</p> <p>2. Захиалагч нь шаардлагатай тохиолдолд баримтын үнэн зөв байдлыг нягтлах үүднээс нэмэлт материал шаардах, хянаж шалгах эрхтэй.</p> <p>3. Бордоо импортлогч компаниуд үгсэн нэгдэж, үнийн дарамт үүсгэхээс урьдчилан сэргийлж хэрэглэгч өөрөө Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар хүсэлт хүргүүлэх нээлттэй байна.</p>
11. Хариуцлага	<p>1. Холбогдох мэдээлэл буруу, бүртгэл дутуу байдлаас шалтгаалан тариалан эрхлэгчээс бордооны хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт ирүүлээгүйгээс хөнгөлөлт олгогдоогүй тохиолдолд тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцлага хүлээхгүй</p> <p>2. Бордоо үйлдвэрлэгчийн санхүүгийн тайлангаар үйлдвэрлэсэн бордооны хэмжээ, худалдсан мэдээлэл зөрүүтэй нь тогтоогдвол холбогдох хуулийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ.</p> <p>3. Хууль тогтоомжийг зөрчиж аливаа баримтыг хуурамчаар үйлдэж олгосон төрийн албан хаагч, тариалан эрхлэгчид, импортлогч нарт холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, хохирлыг нөхөн төлүүлнэ.</p>

Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар